



ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/21

Бэрх хот

Бараа материалыг
актлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Хэнтий аймгийн орон нутгийн өмчийн газрын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 195 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захирагчийн ажлын албаны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 85,516,000 төгрөгний үнэтэй 50 нэр төрлийн 122 ширхэг эд хөрөнгүүд нь эвдэрч, засвар авахааргүй, цаашид ашиглах боломжгүй болсныг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлэсэн тул дараах хавсралт бүхий хөрөнгүүдийг акталж, данснаас хассугай.

2. Хөрөнгийн хасалтыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу бүртгэхийг Нягтлан бодогч /Г.Осгонжаргал/-д даалгасугай.

ДАРГА Э.МЯГМАРСҮРЭН



232502021